# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/232 Сүхбаатар сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол түмний өнө удаан жилийн түүхэн уламжлалтай үндэсний сурын харвааг хөгжүүлэх, Сэлэнгэ нутгийнхаа алдарт харваачдын залгамж халааг бэлтгэх, нум сум бүтээх уламжлалт арга технологийг алдагдуулалгүй хадгалан хөгжүүлж ирсэн Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн, Монгол Улсын мэргэн Ж.Сүхбаатарт хүндэтгэл үзүүлж, мөнгөн шагналаар шагнасугай.

2.Мөнгөн шагналыг олгоход зарцуулагдах 500.000 /таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ